



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 02 сарын 20
өдрийн 717 дугаарт бүртгээ.

2020 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Согтуурах, мансуурах донтой хүнд эрүүл мэндийн дүгнэлт гаргах журам”-ыг нэгдүгээр, “Согтуурах, мансуурах донтой эсэхийг тогтоох эрүүл мэндийн дүгнэлтийн загвар”-ыг хоёрдугаар, “Согтуурах, мансуурах донтой хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох биеийн хүнд эмгэгийн жагсаалт”-ыг гуравдугаар, “Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх журам”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буюнжаргал), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (Д.Дамдинцэрэн), Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Насанцэнгэл)-д тус тус даалгасугай.

1118270972 - 90874

САЙД

(Handwritten signature)
1118270972

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХУУЛГААР ҮНЭН
Хуульч-гэгээч Э.З.Г. 2020 оны 02 сарын 11 өдөр
Д.САРАНГЭРЭЛ

Согтуурах, мансуурах донтой хүнд эрүүл мэндийн дүгнэлт гаргах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Цагдаагийн байгууллагын хүсэлтийг үндэслэн согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон аюулгүй байдлаа хамгаалах чадваргүй болсон хүний согтуурах, мансуурах донтой эсэхийг тогтоох, эрүүл мэндийн дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Дүгнэлт гаргах үйл ажиллагаанд Согтуурах мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон дээрх хуульд нийцүүлэн гарсан тогтоол, журам, стандарт, зааврыг дагаж мөрдөнө.
- 1.3. Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хамруулах үйл ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, үнэн зөв тодорхойлох, шуурхай үйлчлэх зарчмыг баримтална.

Хоёр. Согтуурах, мансуурах донтой хүнд эрүүл мэндийн дүгнэлт гаргах үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1. Согтуурах, мансуурах донтой эсэхийг тогтоолгох, албадан эмчилгээнд хамруулах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргуулахаар цагдаагийн байгууллагаас хандсан хүсэлтийн дагуу тухайн хүний харьяалагдах аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.2. Дүгнэлт гаргах эрүүл мэндийн байгууллага нь согтуурах мансуурах донтой эсэхийг тогтоох эрүүл мэндийн дүгнэлтийн маягтын цагдаагийн байгууллагаас хамааралтай хэсэг бүрэн гүйцэд бөглөгдөн баталгаажуулсан, тухайн хүний баримт бичиг, тодорхойлолтыг хавсаргасан эсэхэд хяналт тавьж, шаардана.
- 2.3. Дүгнэлт гаргуулах иргэний тодорхойлолтод өмнө нь донтох эмгэгийн улмаас сайн дурын болон албадан эмчилгээнд хамрагдаж байсан хэв, журмын зөрчил гаргаж байсан талаарх мэдээллийг тодорхой тусгана.



- 2.4. Согтуурах, мансуурах донтой эсэхийг нь тогтоох дүгнэлт гаргах үйл ажиллагааг бусад үйлчлүүлэгчдэд хүлээгдэл, чирэгдэл үүсгэхгүй байхад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг тухайн эрүүл мэндийн байгууллага авна.
- 2.5. Согтуурах, мансуурах донтой хүнд эрүүл мэндийн дүгнэлт гаргахдаа дараахь оношилгоо, шинжилгээ, үзлэгт үнэ төлбөргүй хамруулна. Үүнд:
- 2.5.1. Цусны ерөнхий шинжилгээ,
 - 2.5.2. Шээсний ерөнхий шинжилгээ,
 - 2.5.3. Биохимийн шинжилгээ (элэг, бөөр, нойр булчирхайн үйл ажиллагаа)
 - 2.5.4. Цусанд сахар илрүүлэх шинжилгээ,
 - 2.5.5. Зүрхний цахилгаан бичлэг,
 - 2.5.6. Цээжний флюор зураг,
 - 2.5.7. Хэт авиан оношилгоо (цуллаг эрхтэн, умай дайвар, түрүү булчирхай),
 - 2.5.8. Бэлгийн замаар дамжих халдварын оношилгоо,
 - 2.5.9. Сэтгэц-донтолт, мэдрэл, дотор, сүрьеэ, мэс засал, арьс, гэмтэл, халдварт, эмэгтэйчүүд, хавдрын эмчийн үзлэгт хамруулна.
- 2.6. Согтуурах, мансуурах донтой хүний эрүүл мэндийн дүгнэлтийг тухай эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ эрхэлсэн даргаар ахлуулан сэтгэц-донтолт, дотрын эмч нарын бүрэлдэхүүнтэй баг (цаашид баг гэх) журмын 2.4-т заасан оношилгоо, шинжилгээ, эмчийн үзлэгт үндэслэн гаргана.
- 2.7. Дүгнэлтэнд өвчний оношийг олон улсын код болон монгол хэлээр бичнэ.
- 2.8. Баг нь дүгнэлт гаргах оношилгоо, шинжилгээ, үзлэгт хамрагдсан иргэний онош, хүндрэл, эмчилгээний гаж нөлөөг хэлэлцэн албадан эмчилгээнд хамруулах болон хориглох шийдвэр гаргана.
- 2.9. Баг нь дүгнэлтийн маягыг үнэн зөв, гүйцэд бөглөн багийн дарга, гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулан дүгнэлт гаргуулахаар илгээсэн цагдаагийн байгууллагад өгнө.
- 2.10. Дүгнэлт гаргах үйл ажиллагааг төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэгт хамруулснаас хойш 24 цагийн дотор багтаана.
- 2.11. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв согтуурах, мансуурах донтой эсэхэд дүгнэлт гаргах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах ба дүгнэлттэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэнэ.
- 2.12. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага албадан эмчилгээнд явуулах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тухайн хүнд оношийг нь танилцуулж, үзлэг, шинжилгээгээр илэрсэн биеийн хүнд эмгэгийг эмчлүүлэх талаар зөвлөгөө өгнө.



2.13. Дүгнэлтээр согтуурах, мансуурах донтой нь тогтоогдсон хүн өөрийн сайн дурын үндсэн дээр сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, архинаас татгалзах мэдлэг чадвар олгох төрийн бус байгууллагын зөвлөгөө, сургалт, соён гэгээрүүлэх үйлчилгээнд хамрагдаж болно.

2.14. Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллага нь өөрийн сайн дурын үндсэн дээр эмчилгээнд хамрагдаж байгаа иргэнд "Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай" хуулийн 6.2-т заасан шаардлагатай лавлагаа тодорхойлолтыг гаргаж өгнө.



-----000-----

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
02 дугаар сарын 05 өдрийн 1/59 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ЭСЭХИЙГ ТОГТООХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДҮГНЭЛТИЙН ЗАГВАР

Дүгнэлт гаргуулахаар илгээсэн байгууллага бөглөх хэсэг:

Дүгнэлт гаргуулах хүний овог, нэр
Нас, Хүйс..... РД:.....
Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар.....
Оршин сугаа хаяг:.....
Холбоо барих утас:.....
Хууль ёсны төлөөлөгчтэй холбоо барих утас:.....
Өмнө нь донтох эмгэгийн улмаас сайн дурын болон албадан эмчилгээнд хамрагдаж
байсан эсэх:
.....

Согтуурах, мансуурах донтой эсэх талаар дүгнэлт гаргуулахаар

.....
(цагдаагийн байгууллагын нэр) албан
тушаалтай цолтой (албан тушаалтын
нэр)-аас (эрүүл мэндийн байгууллагын нэр)-д
илгээв.

Тэмдэг Албан тушаалтны гарын үсэг

(иргэний хувийн баримт бичиг, тодорхойлолтын хамт хүчинтэй)

Хүсэлт гаргасан он сар өдөр

Эрүүл мэндийн байгууллага бөглөх хэсэг:

Сэтгэц-донтолтын эмчийн үзлэг

Дүгнэлт: Согтуурах, мансуурах донтой

Согтуурах, мансуурах донгүй

Шинжилгээнд гарсан өөрчлөлтүүд: (шинжилгээний хариуны эх хувийг хавсаргана) 20



№	Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг	Үзлэгийн тэмдэглэл	Үзлэг хийсэн сар, өдөр	Эмчийн гарын үсэг, хувийн тамга
1.	Дотор			
2.	Сүрьеэ			
3.	Мэс засал			
4.	Арьс			
5.	Хавдар			
6.	Мэдрэл			
7.	Гэмтэл			
8.	Эмэгтэйчүүд			
9.	Халдварт			

Бодит үзлэг

.....

Эмнэлзүйн онош, хүндрэл:

.....

Багийн шийдвэр:

Захиргааны журмаар албадан эмчилгээнд явуулж болох эсэх:

болно болохгүй

Албадан эмчилгээнд хамрагдах боломжгүй шалтгаан (хориглох заалт, гаж нөлөөг бичнэ)

.....

Тэмдэг:

Багийн дарга: /
 гарын үсэг

нэр

Гишүүд: 1. /
 гарын үсэг

нэр

2. /
 гарын үсэг

нэр

Дүгнэлт гаргасан он сар өдөр.



Эрүүл мэндийн сайдын 2020 оны
02 дугаар сарын 05 өдрийн А/Б/Г дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

**Согтуурах, мансуурах донтой хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох
биеийн хүнд эмгэгийн жагсаалт**

1. Идэвхтэй хэлбэрийн сүрьеэ (2023 он хүртэл)
2. Бүх төрлийн хорт хавдар
3. Архаг өвчний эзэншил алдсан үе
4. Эмэнд тэсвэртэй, байнгын үргэлжилсэн унадаг өвчин /эпилепси/
5. Мэс засал шаардлагатай хурц, үечилсэн, товлот, мэс засал ²⁰.....
6. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгасны дараах байдал хүндрэл

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулоор олгосон эжилтны гарын үсэг
B. Зүе
2020 оны 02 сарын 11-ний өдөр

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
02 дугаар сарын 05 өдрийн 1/59 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь согтуурах, мансуурах донтой нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдож, албадан эмчлэх шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг албадан үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Албадан эмчлэх үйл ажиллагаанд Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон дээрх хуульд нийцүүлэн гарсан тогтоол, журам, оношилгоо, эмчилгээний стандарт, зааврыг дагаж мөрдөнө.
- 1.3. Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар (Албадан эмчлэх эмнэлэг гэх) нь үйлчлүүлэгчийг хүлээн авч тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллага хооронд шилжүүлэх, эмнэлгээс гаргах үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, стандартын дагуу эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.

Хоёр. Албадан эмчлэх эмнэлгийн мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт

- 2.1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь албадан эмчлэх эмнэлгийг төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр эрүүл мэндийн технологи, эмнэлзүйн заавар, стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт явуулах, судалгаа шинжилгээ хийх, телемедицинээр болон очиж мэргэжлийн зөвлөгөө, арга зүйгээр хангана.
- 2.2. Албадан эмчлэх эмнэлэг нь тусламж, үйлчилгээнд шаардагдах санхүүжилт, үндсэн орон тоогоор ажиллах хүний нөөцийн чадавх, стандартад нийцсэн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, аюулгүй байдал, тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.
- 2.3. Албадан эмчлэх эмнэлэг нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Наркологийн эмнэлэг, аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран эмчилгээг дуусгавар болгосон хүний бататгах эмчилгээний үр дүн,



дахилт, сэтгэцийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих, мэдээллийн сан үүсгэх, тэдний эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

- 2.4. Дээрх үйл ажиллагаанд мэргэжлийн нийгэмлэг холбоо, сэтгэл заслын чиглэлийн өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийг татан оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

Гурав. Албадан эмчлэх үйл ажиллагаа

- 3.1. Эмнэлэг нь шүүхийн шийдвэр, эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт, иргэний үнэмлэх эсвэл улсын бүртгэлийн байгууллагын лавлагаанд үндэслэн албадан эмчлүүлэх хүнийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй хүлээн авна.
- 3.2. Эмчлүүлэх хүнийг хүлээн авмагц түүнд, өвчний түүх нээж, үзлэг хийж үндсэн ба дагалдах хавсарсан оношийг тогтоож, албадан эмчилгээний зорилго, ач холбогдол, эмнэлгийн дотоод журам, эмчлүүлэгчийн эрх үүргийг танилцуулна.
- 3.3. Албадан эмчилгээг хүний эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандан, эмчлүүлэгчийн нууцыг хадгалах зарчмыг баримтлан, хүчин төгөлдөр мөрдөж байгаа оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 3.4. Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээний хүрээнд явуулах нөхөн сэргээн хөдөлмөр эмчилгээ гэдэгт "Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам"-д заасан сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн алдагдсан чадварыг нөхөн сэргээхэд чиглэсэн физик, оёдол, мужаан гар урлал, үйлдвэрлэл (талх, нарийн боовны цех, гутал засварын газар ажиллуулах, монгол, буриад гутал хийх, хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэх, мал аж ахуйд хэрэглэх ногт, чөдөр зэрэг бүтээгдэхүүн хийх гм) зэрэг эмчилгээг ойлгоно.
- 3.5. Эмчлүүлэгч эмчилгээнээс татгалзсаны улмаас харуул хамгаалалтын ажилтны хяналтан доор албадан эмчилгээг хийсэн, тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэсэн тухай бүрд нь өвчний түүхэнд тодорхой тэмдэглэнэ.
- 3.6. Албадан эмчлэх эмнэлэг нь нарийн төвөгтэй оношилгоо, эмчилгээний асуудлыг хугацаа алдалгүй, зөв шийдвэрлэх зорилгоор "Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагыг арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний хуваарь"-ийн дагуу төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс зөвлөгөө авах үйл ажиллагааг байгууллагын дотоод журмаар зохицуулсан байна.



- 3.7. Эмчлүүлж байгаа хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шуурхай байдлыг хангах, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор явуулын амбулатори, цахим зөвлөгөө, телемедициний сүлжээг ашиглаж болно.
- 3.8. Албадан эмчилгээг эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан анхны эмчилгээг гурваас зургаан сар, давтан эмчилгээг зургаан сараас нэг жил хүртэл хугацаатай хийнэ.
- 3.9. Үйлчлүүлэгчийн эмчилгээний хугацааг дуусгах эсэхийг албадан эмчлэх эмнэлгийн эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцэж дүгнэлт гаргах бөгөөд эмчилгээг дуусгавар болгох дүгнэлт гаргасан тохиолдолд шүүхэд албан бичгээр хүргүүлнэ.
- 3.10. Албадан эмчлэх эмнэлэг нь эмчлүүлэгчийн эмчилгээний хугацаа дуусах тухай мэдээллийг харьяалах нутаг дэвсгэрийн эмнэлгийн сэтгэц-донтолтын эмч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, цагдаагийн байгууллагад эмчилгээний хугацаа дуусахаас долоо хоногийн өмнө албан бичгээр хүргүүлнэ.
- 3.11. Албадан эмчилгээ дуусгавар болсон шүүхийн шийдвэр гарсны дагуу эмчлүүлэгчийг оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын сэтгэц-донтолтын эмч бүртгэн авч, стандарт, зааврын дагуу засаг захиргааны нэгжийн нийгмийн ажилтан, өрх, сумын эмчтэй хамтран батжуулах эмчилгээнд хамруулна.
- 3.12. Албадан эмчлэх эмнэлэг нь эмчилгээний үр дүнг сайжруулах, давтан хэвтэлтийг бууруулах зорилгоор эмнэлгээс гарсны дараах бататгах эмчилгээнд хамруулах, хянах, намжмал байдлыг уртасгах чиглэлээр харьяалах аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын сэтгэцийн эмч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад албадан эмчилгээний явц, цаашид авах арга хэмжээний зөвлөмж, заавар, мэдээллээр ханган эргэх холбоотой хамтран ажиллана.

Дөрөв. Үйлчлүүлэгчийг эмнэлэг хооронд шилжүүлэх, албадан эмчилгээг зогсоох

- 4.1. Албадан эмчилгээнд хамрагдаж байгаа хүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Нэгдсэн эмнэлэг телемедицинээр болон тухайн эмнэлэгт очиж төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр мэргэжил арга зүйгээр дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.2. Сэтгэцийн эмгэгээс бусад шалтгаанаар эрүүл мэндийн байгууллага хооронд шилжүүлэхэд төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлэг нь тусламж,



үйлчилгээний тасралтгүй, шуурхай байдлыг хангахад чиглэсэн мэргэжил арга зүйгээр дэмжлэг үзүүлж ажиллана.

4.3. Яаралтай шилжүүлэх тохиолдолд зохих эмнэлэгт шилжүүлсний дараа тухайн хүний албадан эмчилгээний хугацааг дуусгавар болгох тухай саналыг шүүхэд хүргүүлнэ.

4.4. Яаралтайгаас бусад тохиолдолд албадан эмчилгээг цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэж үзвэл эмнэлэг нь үндэслэлийг гарган тухайн хүний албадан эмчилгээг зогсоох саналыг шүүхэд хүргүүлнэ.

-----o0o-----

